



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 11

Есөнбулаг сум

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны
үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “д” заалт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Амгаланбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Д.ДАВААДОРЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2020 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн
11 дугаар тогтоолын хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн, Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тулгуурлан нам, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналд үндэслэн боловсрууллаа.

НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.1.1. Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээ авах бэлэн байдлыг хангана.

1.1.2. Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад чиглэсэн дэмжлэг, туслалцааг нэмэгдүүлнэ.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1. Эрүүл мэндийн чиглэлээр:

Амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, хүний хөгжлийг дэмжинэ.

2.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгооны хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.1.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан оношилгоо, эмчилгээний нэгжүүдийг өргөтгөн байгуулж, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.

2.1.3. Яаралтай тусламжийн чанар хүртээмж, чадавхыг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.

2.1.4. Цахим үйлчилгээг өргөжүүлэн оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.

2.1.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд гүйцэтгэлд суурилсан

санхүүжилтийн аргыг нэвтрүүлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, Нэгдсэн эмнэлгийн хагас бие даасан тогтолцоог бэхжүүлнэ.

2.1.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын цахим тогтолцоог нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.7.Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.

2.1.8.Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан үйлчлүүлэгчдэд ээлтэй, аюулгүй, стандарт хангасан орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.9.Уламжлалт анагаах ухааны төвийн тусламж үйлчилгээг өргөжүүлж, иргэдэд үзүүлэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2. Биеийн тамир, спортын чиглэлээр:

Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг болгон, иргэдийн биеийн тамир спортын арга хэмжээнд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, идэвхтэй хөдөлгөөн спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулан, тамирчдын бүс, улс, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

2.2.1.“Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил”-д хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлж, нийт хүн амын 30 хувьд хүргэнэ.

2.2.2.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг болгон, биеийн тамираар хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

2.2.3.Спортын заал, талбай, чийрэгжүүлэлтийн танхим, зориулалтын замыг барьж байгуулах талаар аж ахуйн нэгж байгууллагын санаачилгыг дэмжиж ажиллана.

2.2.4.Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багуудыг дэмжин, “Аваргыг аймагтаа” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, тамирчдын залгамж халааг бэлтгэн, ур чадвар, амжилтыг ахиулна.

2.2.5.Монголын бүх ард түмний спортын их наадам, үндэсний спортын их наадам, хүүхдийн спортын их наадам, оюутны спортын их наадмыг орон нутагтаа зохион байгуулж, иргэд, олон нийтийн хамрагдалтыг нэмэгдүүлж, наадмуудад гаргасан өмнөх амжилтыг ахиулна.

2.3. Боловсролын чиглэлээр:

Сургуулийн өмнөх болон бага, суурь боловсролын хамран сургалт, сургалтын чанарыг нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэн, эрдэм мэдлэг, боловсролтой иргэн төлөвшүүлнэ.

2.3.1.“Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр” төслийг хэрэгжүүлнэ.

2.3.2.Бага насны хүүхдийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

2.3.3. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 90.0 хувьд, ерөнхий боловсролын хамран сургалтыг 98.0 хувьд хүргэнэ.

2.3.4. Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон хүмүүжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.

2.3.5. Боловсролын салбарын инновацийг хөгжүүлж, шинэ арга зүй, технологийг нэвтрүүлнэ.

2.3.6. Цахим сургалтын агуулга, хөтөлбөр, хичээлийг боловсруулан, бүх насны иргэдийн насан туршдаа суралцахуйг дэмжиж, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.7. Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийн тоог нэмэгдүүлж, Тайшир сумын сургуулийг түшиглэсэн "Вакумжуулсан сургалт"-ыг нэвтрүүлнэ.

2.3.8. Боловсролын байгууллагыг техник тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангана.

2.3.9. Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх орчны нөлөөллийг бууруулах зорилгоор боловсролын салбарын барилга байгууламж, дэд бүтцийг барилгын норм, дүрэм, стандартад нийцүүлэн сайжруулж, чанарын шаардлага хангасан хүүхдэд ээлтэй сургалтын орчинг бүрдүүлнэ.

2.4. Соёл, урлагийн чиглэлээр:

Ард иргэдэд хүргэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлж, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалт, сурталчилгааг нэмэгдүүлж, нутгийн онцлогийг илэрхийлсэн соёл урлагийн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоно.

2.4.1. Соёл, урлагийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, салбарын хүний нөөц, чадавхыг дээшлүүлж, иргэдэд хүргэх соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, техник тоног төхөөрөмжөөр хангана.

2.4.2. Соёлын салбарын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.

2.4.3. Айл өрхийн угийн бичиг хөтлөлтийг 60 хувьд хүргэнэ.

2.5. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр хэрэгжүүлж, халамж хүртээгч иргэдийн хүрээг багасган, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

2.5.1. "Иргэн бүрт орлого-өрх бүрт өсөлт" арга хэмжээ хэрэгжүүлж, 1000-аас доошгүй байнгын ажлын байрыг шинээр бий болгож, ажилгүйдлийн түвшинг жилд дунджаар 0.5 хувиар бууруулна.

2.5.2. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгож, залуучуудын бизнес санааг хөгжүүлэх, залуучуудаар удирдуулсан бизнесийг шинээр бий болгох START UP арга хэмжээг хэрэгжүүлж, 200-аас доошгүй ажлын байр шинээр бий болгоно.

2.5.3. Өрхийн болон бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, бизнес инкубаторын үйлчилгээ үзүүлнэ.

2.5.4. Сум бүрт Алтайн брэндийг хөгжүүлж, орон нутгийн баялаг бүтээгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалт, маркетингийг дэмжсэн борлуулалтын төв, интернэт худалдааны сүлжээг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран бий болгоно.

2.5.5. Цөөн малтай болон малгүй иргэдийг малжуулах арга хэмжээнд хамруулж, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.5.6. Зорилтот бүлгийн өрх, иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, тэдний онцлогт нийцүүлсэн байнгын ажлын байрыг бий болгоход дэмжлэг үзүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

2.5.7. Хөдөлмөрийн бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

2.5.8. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн 2021-2025 оны тоон судалгааг хийж, үр дүнд үндэслэн мэргэжилтэй ажилтанг бэлтгэнэ.

2.6. Нийгмийн халамж, даатгалын чиглэлээр:

Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдийн нийгмийн баталгаа, амьжиргааг дээшлүүлнэ.

2.6.1. Өрхийн амьжиргааны түвшинг шинэчлэн тогтоож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ядуурлыг бууруулж, халамж хүртэгч иргэдийн хүрээг багасгана.

2.6.2. Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, өрх толгойлсон эцэг, эхчүүдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан цогц бодлогыг орон нутагтаа хэрэгжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

2.6.3. Зорилтот бүлгийн хөгжил хамгааллыг сайжруулж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Хүний хөгжлийн ордон"-г байгуулна.

2.6.4. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, сайн дурын даатгалын хамрах хүрээг өргөтгөх, малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.

2.6.5. Татварт бүртгэлтэй үйл ажиллагаа идэвхтэй явуулж буй аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлнэ.

2.7. Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:

Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүүхдийн эрхийг дээдэлж, хүүхэд хамгааллын тогтолцоо, салбар дундын уялдаа холбоог сайжруулах, залуучуудын хөгжих суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, хариу үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

2.7.1. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, залуучууд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд “Гэр бүлийн хөгжил, хамгаалал”, “Засагт ханы хүүхдүүд”, “Алтайн залуус” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.7.2. Нэг цэгийн үйлчилгээний төвийг стандартад нийцүүлэн, тоног төхөөрөмж, санхүү, хүний нөөцийг бүрдүүлж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангахуйц орчинг бий болгоно.

2.7.3. Хүүхэд залуучуудын ордны “Мазаалай” театрын хүүхэд хөгжлийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулж, хүний нөөцийг бүрдүүлнэ.

2.7.4. Хүүхэд, гэр бүлийн “Хөгжилтэй андууд” зусланг засварлаж, үйл ажиллагааг эрчимжүүлэнхүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлж, “Засагт ханы хот айл гэр зуслан”-г сум бүрт байгуулан Монгол ахуй, ёс заншил, амьдрах ухаанд суралцуулна.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1. Төсөв, санхүүгийн чиглэлээр

Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

3.1.1. Төсвийг төлөвлөх, зарцуулах, хяналт тавих, тайлагнах үе шат бүрт төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлнэ.

3.2. Орон нутгийн өмчийн чиглэлээр

Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.

3.2.1. Орон нутгийн өмчид бүртгэлтэй илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн, эдийн засгийн эргэлтэд оруулж үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.2.2. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын удирдлага, менежментийг сайжруулна.

3.3. Уул уурхайн чиглэлээр

Ашигт малтмалын томоохон ордуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.3.1. Тайшир сумын нутагт орших шохойн чулууны Дөрвөлжингийн ордыг түшиглэн жилд 360 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг байгуулж, төмрийн хүдрийн ордыг түшиглэн төмрийн хүдэр баяжуулах, экспортлох төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.

3.3.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын илрэлийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, орд, илэрцийн мэдээллийн санг үүсгэж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нөөцийг тогтоон, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлнэ.

3.3.3. Хууль бус ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн, ашиглах боломжтой газруудыг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авч, бичил уурхай эрхлэгчдийг дэмжинэ.

3.4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.4.1. Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын шинэлэг, брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

3.4.2. Аялал жуулчлалын салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, ур чадварыг нэмэгдүүлнэ.

3.4.3. Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагуудын хүчин чадал, үйлчилгээг сайжруулж, жуулчдын амрах, үйлчлүүлэх ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5. Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр бүрэн хангана.

3.5.1. “Газар тариалан, жимс, жимсгэнэ” төслийг хэрэгжүүлнэ.

3.5.2. “Атрын IV аян”-ы хүрээнд техник дундын үйлчилгээний төв байгуулан услалтын системийн ашиглалтыг сайжруулж, хөрс хамгаалах, үржил шимийг сайжруулах, үр сортыг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.5.3. Өвөл зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, шинэ ургацын ногооны хангамжийг нэмэгдүүлэх “Дөрвөн улирлын хүлэмж” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.5.4. Хүнсний ногоо болон үрийн нөөцийг хадгалах зоорь барина.

3.5.5. Эрүүл хүнс арга хэмжээг хэрэгжүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангаж, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.5.6. Бизнес хөгжлийн “GATE CENTER” төвийг байгуулж, жижиг, дунд үйлдвэрийг дэмжин бизнес эрхлэгчдийг төсөл, хөтөлбөрт хамруулж, хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.

3.5.7. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлнэ.

3.5.8. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжин, үйл ажиллагааг сайжруулж ажлыг байрыг нэмэгдүүлнэ.

3.5.9. Говь-Алтай үүлдрийн хонь, Төхөм тунгалагийн хүрэн үүлдрийн тэмээний генийн санг хамгаалах, ашиглах, сайжруулах, Бугатын "Хөвчийн улаан" болон Цогтын "Мөнгөн сорт" ямааг омог, хэвшлээр батлуулах, хянан магадлагааны ажлыг зохион байгуулна.

3.5.10. Услалтын системүүд болон төв суурин газрыг түшиглэн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ.

3.5.11. Мал, амьтны гоц халдварт өвчингүй эрүүл бүс нутгийг хадгалж, малын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.5.12. Мал эмнэлгийн гэрчилгээний цахим систем нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлж, малын шилжилт хөдөлгөөнийг онлайн бүртгэлд оруулж, эрүүл баталгаатай мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлнэ.

3.5.13. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, хортон мэрэгчтэй тэмцэж, ашиглалтыг сайжруулна.

3.5.14. Мал сүргийн эрсдэлийг бууруулах, даатгалд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.

3.6. Дэд бүтцийн чиглэлээр:

Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлболон Алтай хотын усан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос хангана:

3.6.1. Алтай хотод баригдах 25МВт-ын хүчин чадалтай дулааны станцыг барьж ашиглалтад оруулж, 2-р хэлхээний шугам сүлжээг шинэчлэн хэрэглээний халуун устай болгоно.

3.6.2. Алтай хотын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах "Тайшир-Алтай" усан хангамжийн төслийн ажлыг ашиглалтад оруулна.

3.6.3. Тайшир-Есөнбулаг сум чиглэлийн 35 кВ-ын ЦДАШ-ыг 110 кВт болгон өргөтгөж, аймгийн төв болон сумдын цахилгаан эрчим хүчний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Төрийн үйлчилгээг цахимжуулж, авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, иргэний оролцоотой, нээлттэй, ил тод, хариуцлагатай засаглалын бодлого хэрэгжүүлнэ.

4.1. Төрийн үйлчилгээний чиглэлээр

4.1.1 Төрийн байгууллагуудын чиг үүргийг уялдуулан бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн сахилга, хариуцлагыг чангатгана.

4.1.2. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор “Цахим-Алтай” арга хэмжээ хэрэгжүүлж, үйлчилгээний нэгдсэн төвөөр үзүүлэх, үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ.

4.1.3. Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.

4.1.4. Сумдыг улсын бүртгэлийн онлайн системд холбох ажлыг үргэлжлүүлнэ.

4.1.5. Төрийн архивыг зориулалтын байртай болгож, тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

4.1.6. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ.

4.2. Авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр

4.2.1. Төрийн үйл ажиллагааны бүх шатанд хуулийн зөв хэрэглээг төлөвшүүлж, авлигыг таслан зогсоох, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэхэд төр, иргэн, иргэний нийгмийн байгууллагуудын мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлнэ.

4.2.2. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, зөрчлийг бууруулах, бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлнэ.

4.2.3. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлж, тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

4.2.4. Аймгийн төвийн гэр хорооллын хяналтын камертай гудамжны тоог нэмэгдүүлнэ.

4.3. Батлан хамгаалах чиглэлээр

4.3.1. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн, иргэд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад шалган туслах ажлыг зохион байгуулж иргэний цэргийн үүргийн биелэлтийг хангуулна.

4.3.2. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, оюутан цэргийн тоог нэмэгдүүлнэ.

4.3.3. Барилга-инженерийн цэргийн анги байгуулах асуудлыг шийдвэрлэх талаар холбогдох яам, газартай хамтран ажиллана.

4.4. Гамшгаас хамгаалах чиглэлээр

4.4.1. Гамшгийн бэлэн байдлын бодлого, төлөвлөлтийг шинэчлэн, гамшгаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хор уршгийг шуурхай арилгах менежментийг хэрэгжүүлнэ.

4.4.2.Есөнбулаг сумд Эрэн хайх, аврах салбар, Цогт сумд Эрэн хайх, аврах бүлгийг байгуулж,алба, мэргэжлийн ангиудын бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлж, техник хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлнэ.

4.5. Мэргэжлийн хяналтын чиглэлээр

4.5.1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж, иргэдийн эрүүл мэнд, нийгмийн болон орчны аюулгүй байдлыг хангана.

4.6. Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр

4.6.1. Гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалж, харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн, хилийн шинэ гарц нээх асуудлыг судлах, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.1. Хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг хийж, нөөцийг тогтоон, бохирдож, хомсдохоос сэргийлж, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэн ундны усны чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангах бодлогыг олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

5.1.2. Хөрсний үржил шим, чийгийг ойн зурвас, хөв цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хаших замаар хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээнэ.

5.1.3. Монгол бөхөн, тарвага, Халиун бугыг сэргээн нутагшуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

5.1.4. Ойн сан бүхий газарт ой зохион байгуулалтын ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг зохион байгуулна.

5.1.5. “Ногоон-Алтай” арга хэмжээг хэрэгжүүлэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд хот, суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шинэчлэх ажлыг зохион байгуулна.

5.1.6. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах цогц үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ.

5.1.7. Төв суурин газрын орчны бохирдлыг бууруулах, иргэдийн тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сэргээгдэх эрчим хүч, шинэ техник технологид тулгуурласан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.1.8. Экоосистемийн чухал ач холбогдол бүхий газар нутгуудыг тусгай хамгаалалтад авч, хамгааллын загвар менежментийг бий болгоно.

5.1.9. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.

ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6.1. ЭРЧИМ ХҮЧНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн төв болон сумдад цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

6.1.1. Багийн төв, төвлөрсөн суурин газрыг байнгын эрчим хүчний эх үүсвэртэй болгож, малчин өрхүүдийн цахилгааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

6.1.2. Алтай хотын гэр хороололд хоёр тарифт цахилгаан тоолуур суурилуулж, хэрэглэгчдэд ээлтэй систем нэвтрүүлнэ.

6.1.3. Алтай сумын цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгоно.

6.2. ЗАМ ТЭЭВРИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Улсын болон орон нутгийн чанартай авто зам, гүүрний арчлалт, ашиглалтыг сайжруулж, гудамж, зам талбайг тохижуулж, авто зам ашигласны төлбөр хураах журам боловсруулж, төлбөр хураах цэгийг байгуулна.

6.2.1. Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан 5-аас доошгүй км хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулна.

6.2.2. Дугуйн болон явган хүний зам төслийг хэрэгжүүлнэ.

6.2.3. Алтай хот-Бургастайн боомт чиглэлийн 320 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

6.2.4. Алтай–Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг барьж ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ.

6.2.5. Алтай хотод “Авто вокзал”-ын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулж, тээврийн үйлчилгээг сайжруулна.

6.2.6. Алтай хотын хатуу хучилттай авто замын үерийн ус зайлуулах байгууламжийг шинээр бий болгоно.

6.2.7. Орон нутгийн чанартай авто зам, гүүрийн байгууламжийн засвар арчлалтыг гүйцэтгэнэ.

6.3. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО:

Мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлнэ.

6.3.1. Алтай сум, Баянтоорой тосгоныг өндөр хурдны интернетийн шилэн кабелийн сүлжээнд холбож, интернетийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

6.3.2. Өндөр хурдны телевизийн сигнал дамжуулах "IPTV" технологийг сумдад нэвтрүүлнэ.

6.3.3. Сум суурин болон алслагдсан багуудад үүрэн холбооны 3G, 4G сүлжээгээр хангана.

6.4. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтыг нэгдмэл удирдлагаар хангана.

6.4.1. "Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил" төсөл хэрэгжүүлнэ.

6.4.2. Есөнбулаг сумд "Хөгжлийн гудамж" төслийг хэрэгжүүлж, Алтай хотыг орчин үеийн хот болгох суурийг эхлүүлнэ.

6.4.3. Есөнбулаг сумын Индэрт, Баянхайрхан, Харзат, Түмэн багийн гэр хорооллыг дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбоно.

6.4.4. "Солонго" хорооллын дэд бүтцийг түшиглэн хямд өртөг бүхий, гадна тохижилтыг бүрэн шийдсэн стандартад нийцсэн нийтийн орон сууцны хорооллыг барьж ашиглалтад оруулна.

6.4.5. Алтай хотын соёл, амралтын хүрээлэнг "Мазаалай" цогцолбор болгон өргөжүүлж, ашиглалтад оруулна.

6.4.6. Барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлж, сорил шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

6.4.7. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, газар олголтыг ил тод болгоно.

6.4.8. Бэлчээрийн төлөв байдлыг судлан үр дүнг малчдад хүргэж, бэлчээр зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.

6.4.9. Хаягжилтын нэгдсэн системийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.

6.4.10. Алтай хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, сумдын төвийг усан хангамж, ариутгах татуургын нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэж, бага оврын цэвэрлэх байгууламжтай болгоно.

6.4.11. Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх орчны нөлөөллийг бууруулах зорилгоор эмнэлэг, сургууль, цэцэрлэг, дотуур байр (нүхэн жорлонтой)-ыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

6.4.12. Алтай хотын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний 3 дугаар ээлжийн ажлыг эхлүүлж, инженерийн байгууламжийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.

---oOo---